



### ХЭНТИЙ АЙМГИЙН БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 14 өдөр

Дугаар A/59

Биндэр сум

Аудитын дүгнэлт, албан шаардлага, акт,  
зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх  
арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аудитын дүгнэлт, албан шаардлага, акт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг хавсралтад заагдсан хугацаанд Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлэн ажиллахыг байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3.Хэрэгжилтийн явцад хяналт тавьж, үр дүнг танилцуулан ажиллахыг Санхүү албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мишээлт)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН



Биндэр сумын Засаг даргын 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн захирамжийн хавсралт



**АУДИТЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ, АЛБАН ШААРДЛАГА, АКТ, ЗӨВЛӨМЖИЙН МӨРӨӨР  
АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2026.04.17

№	Байгууллаг а	Зөрчлийн товч утга	Зөрчлийн дэлгэрэнгүй	Зөрчлийн дүн	Биелэлтийн хугацаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах албан тушаалтан
1	Засаг даргын Тамгын газар	Төсвийг үндэслэлтэй төлөвлөдөггүй <b>Албан шаардлага</b>	-Сумын 2025 оны төсвийг тодотгон баталсан боловч орон нутгийн ерөнхий орлогын урьд оны үлдэгдлийг бүрэн төлөвлөөгүй -Хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлийг илүү дүнгээр төлөвлөж батлуулсан -Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлийг илүү дүнгээр төлөвлөж батлуулсан	51,659,157.00₮  22,623,299.00₮  365,411.00₮	2026.10.20	-Төсөвт тодотгол хийхдээ төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх эх үүсвэрээр бүрэн нөхдөг байхаар тооцоолж, төсвийг тэнцвэржүүлэх - Хөрөнгө оруулалтын арга хэмжээг санхүүжилт, эх үүсвэртэй уялдуулан боловсруулах	Санхүү албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Мишээлт  Сан хариуцсан нягтлан бодогч Х.Гангансүвд
2	Засаг даргын Тамгын газар	Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан – <b>Албан шаардлага</b>	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлбэл зохих олон нийтийн цагдаагийн цалинг ЗДТГ-ын үндсэн үйл ажиллагааны зардлаас олгосон.	10,519,704.00₮	2026.05.20	Батлагдсан орон тооны хязгаараас давсан томилгоо хийхгүй байх, цалин хөлс олгохгүй байх, олон нийтийн цагдааг чөлөөлөх.	ЗДТГ-ын дарга Г.Өнөболд, ЗДТГ-ын нягтлан бодогч Г.Амгаланцэцэг

8	Цэцэрлэг	Албан шаардлага Эдийн засгийн ангилал зөрчин төсвийг зориулалт бусаар зарцуулсан- Албан шаардлага	Тайлант онд мэдээллийн технологийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчин хөрөнгө худалдан авч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1,525,000.00₮	2026.05.25	шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах Сангийн сайдын 2025 оны Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай 112 дугаар тушаалын дагуу эдийн засгийн ангиллын дагуу гүйлгээ хийх	Цэцэрлэгийн нягтлан бодогч Д.Одонгэрэл
9	Гутайн даваа-Хөмүүл голын эхийн БЦГХЗ	Шилэн дансны цахим сайтad мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээлдэггүй Албан шаардлага	Шилэн дансны цахим сайтad жилийн эцсийн санхүүгийн тайланг хугацаа хоцроож мэдээлсэн, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 1 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3 гүйлгээ, цалингийн зардлаас бусад, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1 гүйлгээ, хөрөнгө мөнгө зарцуулах 8 шийдвэрийг байршуулаагүй.	5,000,000.00₮ 80,518,300.00₮ 5,000,000.00₮ 11,855,448.00₮	2026.05.20	-Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлэх - Шилэн дансны сургалт, мэдээлэл авах	Гутайн даваа-Хөмүүл голын эхийн БЦГХЗ-ы нягтлан бодогч Ө.Баярцэцэг
10	Ерөнхий боловсролын сургууль	Хууль журам зөрчин илүү цалин олгосон Төлбарийн акт	-7 ажилтанд ээлжийн амралтын олговор, цалинг давхардуулан - 1 албан хаагчид сахилгын шийтгэлтэй хугацаанд нь - 2 албан хаагчид илүү цагийн нэмэгдлийг	2,868,101.00₮ 257,580.00₮ 415,701.00₮	2026.05.25	Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого"-ын 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх	ЕБС-ийн захирал Д.Дамдинпүрэв ЕБС-ийн нягтлан бодогч Э.Ононтунгалаг

11	Ерөнхий боловсролын сургууль	ХАА-г цахимаар зохион байгуулдаггүй, шууд гэрээ байгуулан худалдан авалт хийдэг <b>Албан шаардлага</b> ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг баталдаггүй, хэрэгжилтийг дүгнэдэггүй.	Тогтоосон хугацаанаас хэтрүүлэн цалин олгосон. Тайлант онд худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг tender.gov.mn цахим системээр зарлаагүй худалдан авалт хийсэн.	252,756,100.00₮	2026.05.25	Хоол, хүнсний худалдан авах ажиллагааг тендерийн цахим системээр зохион байгуулж, шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах	ЕБС-ийн захирал Д.Дамдинпүрэв
12	Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг баталдаггүй, хэрэгжилтийг дүгнэдэггүй.	Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ – ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг батлаагүй, ОНӨААТҮГ – ын захиралтай гэрээ байгуулаагүй, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй байна.		2026.09.20	Сумын Засаг даргын зөвлөлөөр : -Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг батлуулах - Менежментийн төлөвлөгөө батлуулах - Санхүүгийн тайлан танилцуулах, дүгнүүлэх	Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дарга Г.Баярхүү, нягтлан бодогч Э.Солонго
13	Бүх төсөвт байгууллагууд	Нягтлан бодох бүртгэлийн нийтлэг алдааг засаж залруулах, программд ажиллах чадварыг нэмэгдүүлэх, тайлан тооцоог үнэн зөвөөр илэрхийлэхэд энэ сургалтын зорилго оршино. Хамрах хүрээ- Байгууллагын нягтлан бодогч, нярав			2026.05.01	Нягтлан бодох бүртгэлийн СиТиЭс программын сургалтад хамрагдах	Санхүү албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Мишээлт
14	Бүх төсөвт байгууллагууд	Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, цахим тендерийн системд ажиллах, тендерийн баримт бичгийг боловсруулах арга зүйтэй болоход энэ сургалтын зорилго оршино. Хамрах хүрээ- Байгууллагын АЗ сертификат эзэмшигч			2026.10.01	Худалдан авах ажиллагааны газартай хамтран сургалт зохион байгуулах	Санхүү албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Мишээлт